



*The **AMERICAN CHAMBER** of Commerce in Mongolia*

ХУВИЙН ХЭВШИЛД ТУЛГУУРЛАСАН ӨСӨЛТӨД ХҮРЭХ ЗАМ 2022

2022 оны 1 дүгээр сар

Оршил

“Өсөлтөд Хүрэх Зам” нь Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (цаашид АмЧам Монгол гэх) бодлогын тэргүүлэх чиглэлүүд болон үйл ажиллагааны стратегийг тусгасан бодлогын баримт бичиг бөгөөд Монгол улсад бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Америкийн бизнес эрхлэгчид болон Монгол дахь манай танхимын гишүүдэд өрсөлдөөний ижил нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм.

2022 оны бодлогын тэргүүлэх үндсэн чиглэлүүд

1. Монгол улсад хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн сэргэлт болон өсөлтийг дэмжих;
2. АНУ болон Монгол улсын хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн харилцаа холбоо, түншлэлийг бэхжүүлэх;
3. Гишүүдийнхээ ашиг сонирхолд нийцсэн дэмжлэг үзүүлэх, тэдний брэндийг сурталчлан таниулах.

Үндсэн чиглэлүүдийг дэлгэрэнгүй дурьдвал:

1. Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн сэргэлт, өсөлтийг дэмжихдээ гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтын бодлогод голлон анхаарах, гишүүдийн үйл ажиллагаа эрхэлдэг салбаруудад чиглэсэн эдийн засгийн сэргэлт, өсөлтийг дэмжих, үүнд уул уурхай, ашигт малмал, хөдөө аж ахуй, санхүүгийн үйлчилгээ, дижитал шилжилт, худалдаа арилжаа, эрчим хүч, авто болон агаарын тээвэр зэрэг салбарууд багтана.

Ковид-19 цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд Засгийн газар их хэмжээний зарлага гаргахын зэрэгцээ орлого буурах нөхцөл бий болсон. Цар тахал нь хоёр хөршийн бодлогын шийдвэрээс Монгол улсын эдийн засаг ихээхэн хамааралтай байдгийг харуулсан төдийгүй гуравдагч хөршүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгох бодлого хэрэгтэйг онцлон харууллаа.

Америкийн бизнесүүд болон манай гишүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор АмЧам Монгол нь гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтын бодлогыг тууштай дэмжих болно. Энэхүү бодлого нь хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжих ба зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг хумьж, бие даасан байдлыг сааруулж, хөрөнгө оруулалт болон инновацийг бууруулж буй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өсөлтийг хязгаарлахад чиглэх ёстой.

Энэхүү бодлого нь хуулийг дээдлэх, гэрээ байгуулсан талууд үүргээ бүрэн биелүүлдэг байх, татварын тогтвортой дэглэмийг дэмжих, хөрөнгө оруулалт, бизнесийн илүү таатай орчныг бүрдүүлэх ёстой. Авлигатай тэмцэх, хөрөнгө оруулагчид болон



бизнесийн маргааныг цаг алдалгүй шийдвэрлэхэд чиглэсэн ил тод, тууштай, хэрэгжихүйц хууль эрхзүй, зохицуулалтын орчныг дэмжих нь чухал юм.

АмЧам Монгол нь эдгээр ажлуудыг Засгийн газар, бизнесүүд, худалдааны танхимууд, салбарын холбоод болон бусад түншүүдтэйгээ хамтран ажиллаж хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

- Чөлөөт зах зээлийн эдийн засагт хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтөд чиглэсэн гуравдагч хөршийн хөрөнгө оруулагчид болон гуравдагч хөрштэй бизнес хийж буй Монголчуудын хөрөнгө оруулалт, бизнесийн онцлог хэрэгцээг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хамтран **гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах;**
- Хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэл, ашигт малтмал, баялгийн сан, гадаад худалдаа, дижитал шилжилт, виртуал хөрөнгүүд, валютын зохицуулалт зэрэг болон бусад чиглэлүүдийн хууль тогтоомжийг шинэчлэх зорилгоор холбогдох хуулиудын ажлын хэсэгт оролцох замаар **Монгол улсын хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийн бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахын тулд ил тод, хүртээмжтэй хууль тогтоох үйл явцад оролцох оролцоог улам нэмэгдүүлэх. Түүнчлэн, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах талаар бодлогын өмгөөлөл хийх;**
- 2021 онд бий болгосон үйл ажиллагааны цар хүрээ, суурийг бататган, “Өсөлтөд хүрэх зам” бодлогын баримт бичигт тусгагдсан бодлогын үндсэн чиглэлүүдийн хүрээнд эдийн засгийн **үндсэн салбаруудын тулгамдсан асуудлуудаар төр-хувийн хэвшлийн хэлэлцүүлэг өрнүүлэх, УИХ, Засгийн газрын бүх шатны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх;**
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын талаарх олон нийтийн сөрөг ойлголтыг өөрчлөх зорилгоор **Монгол улс дахь ГШХО-ын үр өгөөжийг зөвөөр таниулан сурталчлах олон талт хамтын ажиллагаанд түшиглэсэн кампанит ажлыг зохион байгуулж, манлайлан ажиллана.**

АмЧам Монголын гишүүд нь Уул уурхай, Санхүү, Хөдөө аж ахуй, Худалдаа, Авто тээвэр, Мэдээллийн технологи, дижитал эдийн засгийн хороодоор дамжуулан дээрх үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ чөлөөт зах зээл, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн төрөлжилт болон нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжинэ.

Түүнчлэн COP26 чуулганы дараа дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх сүүлийн үеийн чиг хандлагын дагуу АмЧам Монгол нь Санхүүгийн хороогоор дамжуулан ногоон санхүүжилт болон ногоон эдийн засгийг дэмжин ажиллана.



2. АмЧам Монголын Худалдааны хороо, АНУ болон Монгол улсын дээд түвшний оролцогч талуудтай хоёр талт хамтын ажиллагаа, АНУ-ын Худалдааны танхим болон Ази Номхон далайн орнуудын АмЧамуудын холбоо (AAP)-ны бүсийн гишүүнчлэл, Энэтхэг-Номхон далайн Америкийн холбоо (AAIP)-нд нэгдсэнээр АНУ болон Монгол улсын хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн харилцаа холбоо, түншлэлийг бэхжүүлэх

АНУ болон Монгол улсын хоёр талын харилцаа, тэр дундаа бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон дипломат төлөөлөгчдийн харилцаа холбоог бэхжүүлэн, өргөжүүлэх нь АмЧам Монголын эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой билээ. Хоёр улсын хооронд одоо байгаа хууль эрх зүйн орчныг ашиглаж, түүнд тулгуурлан хоёр талт худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зорилгоор богино, дунд, урт хугацааны зорилтуудыг тусгасан илүү уялдаатай, төвлөрсөн гуравдагч хөршийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх боломж бий.

Монгол улс, АНУ болон бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн хооронд худалдаа, нөлөөллийн ажлын хүрээнд нягт хамтран ажиллах нь бизнес, худалдааг нэмэгдүүлэх, хувийн хэвшилд тулгуурласан өсөлтийг бий болгох, Монголын эдийн засгийг сэргээн эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой. АмЧам Монгол нь гурван сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоо болох Америкийн худалдааны танхимын гишүүн. Мөн АмЧам Монгол энэ байгууллагын Ази номхон далайн бүс нутгийн 28 Худалдааны танхимаас бүрдсэн зөвлөлд харьяалагдаж, тус бүсийн орнууд дахь салбар байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Энэ жил бид Энэтхэг-Номхон далайн орнуудын Америкийн Холбоо (AAIP)-нд нэгдэхээр төлөвлөөд байна. Бид энэхүү бүсийн холбоо харилцаагаар дамжуулан Байдены засаг захиргааны Энэтхэг-Номхон далайн эдийн засгийн бодлоготой үйл ажиллагаагаа уялдуулах, Вашингтон болон бүс нутгийн бодлого боловсруулагчидтай харилцах, дэлхийн, бүс нутгийн болон орон нутгийн бизнесүүдийг холбох, гуравдагч хөршийн худалдааны бодлого боловсруулах, зөвлөгөө өгөх нөөц боломжийг бүрдүүлэх боломжтой болох юм.

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

- Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд АНУ, Монгол улсын хоорондын худалдааг нэмэгдүүлэхэд чиглэсэн боломжуудыг судлах;
- АНУ, Монгол улсын хоорондын худалдааг нэмэгдүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газартай хамтран гуравдагч хөршийн худалдааны бодлого боловсруулж, Монгол улстай хийх хоёр талт болон бүс нутгийн худалдааг цаашид нэмэгдүүлэх тодорхой зорилтуудыг тодорхойлох;
- АмЧам Монголын гишүүдийг бусад гишүүдтэй, бүс нутгийн болон АНУ-ын зах зээлтэй холбоо тогтооход туслах;
- АНУ руу хийх бизнес (Doorknock, Certified Trade Mission) аялалуудыг зохион байгуулах, АНУ-ын төрийн өндөр албан тушаалтнуудыг Монгол улсад айлчлах, Монголын төрийн өндөр албан тушаалтнуудыг АНУ-д айлчлах ажлуудыг зохион байгуулах;
- Жил тутмын “Америкийн өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, түүнчлэн АНУ-д зохион байгуулагдах “Монголын өдрүүд” экспог дэмжих;



- Ази, номхон далайн орнуудын Америкийн худалдааны танхимуудын Зөвлөл (ААР)-ийн бүсийн бага хуралд Монгол улсын төлөөлөгчдийг оролцуулж, Монголд бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр бүс нутгийн тэргүүний туршлага, жишээнээс суралцах боломжоор хангах;
- АНУ-ын Конгрессын Монголын бүлэг болон УИХ дахь Монгол-АНУ-ын парламентын бүлэгтэй идэвхитэй хамтран ажиллах;
- Хоёр талт эдийн засаг, худалдааны харилцааг өргөжүүлэх, Монгол дахь бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор АНУ-Монгол улсын хооронд байгуулсан ил тод байдлын хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын өмгөөллийн ажлуудыг үргэлжлүүлэх;
- Бодлогын асуудлуудаар яриа хэлэлцээ, хэлэлцүүлгийг өргөжүүлэх, бүс нутгийн болон дэлхийн бизнесийн удирдагчид, бусад оролцогч талуудыг урьж оролцуулах зэрэг болно.

3. Гишүүдийнхээ ашиг сонирхолд нийцсэн дэмжлэг үзүүлэх, тэдний брэндийг сурталчлан таниулах

АмЧамын гишүүд нь Монгол улсад ашигт малтмал болон ашигт малтмалын бус салбарт хөрөнгө оруулалт хийж, бизнес эрхэлж байна. Манай гишүүд хамгийн шинэлэг технологи, машин техник, тоног төхөөрөмж, шилдэг туршлагыг ашигласнаар тухайн салбарт олон улсад өрсөлдөх чадвартай болох, илүү их орлого олох, хүрээлэн буй орчныг хамгаалах, ажлын байр бий болгох, орчин үеийн ажиллах хүчийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чадамжийг бий болгодог. Түүгээр ч зогсохгүй манай гишүүд авлигын эсрэг хүчин чармайлтыг дэмжиж улмаар олонхи нь АНУ-ын Гадаад дахь Авлигатай тэмцэх тухай (the U.S. Foreign Corrupt Practices Act) хуулийг дагаж мөрддөг.

АмЧам нь гишүүддээ төдийгүй хөдөө аж ахуй, санхүүгийн үйлчилгээ, бичил эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч болон бусал салбаруудад үйл ажиллагаа эрхэлдэг Америкийн компаниудад боломжуудыг бий болгох зорилгоо үргэлжлүүлж, гишүүдээрээ дамжуулан Монгол улсад хөрөнгө оруулалт татах, дэвшилтэт технологи, ноу-хауг нэвтрүүлэхийн төлөө ажиллах болно.

АмЧам гишүүддээ зориулсан дэмжлэг үзүүлж, тэдний брэндийг таниулах олон арга замуудыг эрэлхийлэх болно.

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

- Гишүүдийнхээ хэрэгцээ шаардлагад тохирсон бодлогын нөлөөллийн ажлуудаар дамжуулан тэдэнд үйлчлэх;
- Улс төр, эдийн засаг, бодлогын хөгжлийн талаар цаг тухайд нь өндөр чанартай мэдээлэл, дүн шинжилгээг гишүүдэд хүргэх;
- Төрөл бүрийн сувгуудаар дамжуулан гишүүдийнхээ брэндийг сурталчлах, бодлогын хороод, арга хэмжээ, уулзалтуудад оруулж буй гишүүдийнхээ хувь нэмрийг нь үнэлэх;
- Нийгмийн хариуцлагын хороогоор дамжуулан гишүүдийнхээ шилдэг туршлага, амжилтыг таниулах замаар Монголын бизнес эрхлэгчдийн хүрээнд нийгмийн хариуцлагын соёлыг түгээн дэлгэрүүлэх болно.

